



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/М

Улаанбаатар хот

Иргэдийг үнэлгээний хорооны
бүрэлдэхүүнд томилон ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/254 дүгээр тушаалын хавсралтын 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит V хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх АЗ сертификат олгох сургалтад хамрагдаж тэнцсэн иргэдийг Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажиллах хараат бус ажилтнаар томилсугай.

2.Үнэлгээний хорооны хараат бус гишүүнээр ажиллах иргэдийн нэрсийг хавсралтаар баталсугай.

3.Дүүргийн нутаг дэвсгэрт амьдардаг, гэрчилгээ авсан иргэний жагсаалтыг тогтмол хөтөлж, шинэчилж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (М.Давааням)-д, иргэдийг үнэлгээний хорооны хараат бус ажилтнаар бэлтгэх сургалт зохион байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Санжийжамц)-д, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллахыг Худалдан авах ажиллагааны албаны дарга (О.Содовжамц) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд)-д даалгасугай.

5.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/27 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ

E:\2025 он\Тогтоол А.docx

1107010039